

1

БАТЛАВ
СУМЫН ЗАСАГ ДАРГА

Ч. ГАНХУЯГ

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАЙРХАНДУЛААН СУМ

**ХҮНСНИЙ ЭРХИЙН БИЧГЭЭР ҮЙЛЧИЛГЭЭ
ҮЗҮҮЛЭХ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН
ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕР**

2020 ОН

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХАРХАНДУЛААН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Огноо: 2020.01.15

**ХҮНСНИЙ ЭРХИЙН БИЧГЭЭР ҮЙЛЧЛЭХ
НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ӨВАХДСЗДТГ/202001005 БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр:

**ХҮНСНИЙ ЭРХИЙН БИЧГЭЭР ҮЙЛЧЛЭХ
НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕР**

**Харьцуулалт/
төслийн дугаар:**

**Харьцуулалтын аргаар бараа нийлүүлэх
ӨВАХДСЗДТГ/202001005**

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Өвөрхангай аймгийн Хайрхандулаан сум ЗДТГ нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **[Хүнсний эрхийн бичгээр үйлчлэх нийлүүлэгч]**-ийг сонгон шалгаруулах тендерт үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү үйлчилгээний тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендэр шалгаруулалт зохион байгуулах журам”-ын дагуу зохион байгуулж байна. Тендер шалгаруулалт Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Үнийн саналыг **[2020 оны 01 дүгээр сарын 23 өдрийн 14 цаг]**-аас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **[2020 оны 01 дүгээр сарын 23]**-ны өдрийн **[14³⁰]** -т нээнэ.

Тендэрт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50.000 /тавин мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна.
Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

[ЗДТГ 99944801, 88434048]

Хайрхандулаан сум

Үнэлгээний хороо

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|---|--|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
1. Үнийн санал, Хүнсний барааны нэр төрөл, тоо хэмжээ, нэг бүрийн үнийг нарийн дэлгэрэнгүй заах
2. Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
3. Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, татвар болон нийгмийн даатгалын тодорхойлолт/ болон бусад баримт бичиг;
4. Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
5. Захиалагч тендэрт оролцогчийн талаар санхүүгийн болон бусад мэдээллийг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендэрт оролцогчийн албан мэдэгдэл
6. Тендерийн баримт бичгийн үнийг төлсөн баримт |
| 4. Тендерийн үнэ | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байна. Сүү, мах, хүнсний ногоо зэрэг улирлын чанартай бүтээгдэхүүнд тохируулгатай, бусад бүтээгдэхүүнд тогтмол байна. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |
| 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх | 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |
| 8. Гэрээ | 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас |

**байгуулах эрх
олгох тухай
мэдэгдэл**

өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ul style="list-style-type: none"> - Сүүлийн [2] жилийн санхүүгийн тайлан /2018, 2019 он/; - Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар; - Сүүлийн [3] жилийн туршлагын мэдээлэл /ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн гэрээний хуулбар/; - Сүүлийн [1] жилд ашигтай ажилласан байх ба борлуулалтын орлого нь 20.000.000 /хорин сая/ төгрөгөөс доошгүй байх. - Түргэн хөрвөх боломжит хөрөнгө буюу зээлжих чадварын хэмжээ санал болгож буй үнийн дүнгийн 30%. - Татвар болон нийгмийн даатгалын өргүй байх; - Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: [хүнсний болон худалдаа эрхэлдэг тохирлын гэрчилгээний хуулбар.]
ТӨӨЗ 2.1	<p>Тендерт оролцогч нь боловсруулсан тендерийн иж бүрдэл, баримт бичгийг электрон хэлбэрт хөрвүүлж цахим хэлбэрээр ирүүлнэ.</p> <p>Тендэр хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>[[2020 оны 01 дүгээр сарын 23]-ны өдөр [14⁰⁰]цаг.</p> <p>Тендэр хүлээн авах эцсийн хугацаа нь цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn –ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийг хүлээн авах боломжгүй.</p> <p>Тендэр хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө илгээсэн тендерийн материалаа засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрх нээлттэй.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: [Хайрхандулаан сумын ЗДТГ]</p> <p>Давхар болон өрөөний дугаар: [ЗДТГ-ын даргын албан өрөөнд]</p> <p>Огноо: [[2020 оны 01 дүгээр сарын 23]-ны өдрийн [14³⁰] цаг.</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: [Багц байхгүй, бүтээгдэхүүн тус бүрийн сонголт хэд хэд байж болно,]</p>

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Техникийн тодорхойлолтын хураангуй. Нийлүүлэгдэх бараа болон холбогдох үйлчилгээ нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

Хайрхандулаан сумын төв дотор хүнсний эрхийн бичгээр үйлчилнэ.

Нэртөрлийндугаар	Барааболонхолбогдохүйлчилгээнийнэр	Хэмжихнэгж	Техникийнтодорхойлолтболонстандарт
1. Гурил, гурилан бүтээгдэхүүн	1. Гурил 2. Боорцог 3. Талх 4. Гоймон 5. Езвэн 6. Печень	Кг Кг Кг Кг Кг Ш	<p>Гурил гурилан бүтээгдэхүүнд худалдан борлуулахаар зөвшөөрөгдсөн бүтээгдэхүүн байх бөгөөд бялуу, кекс хамаарахгүй. Импортын бус байна.</p> <p>Бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг зааж ирүүлнэ. Тухайлбал: стимо, өгөөж, талх чихэр, итгэл, дэлгэрэхийн боорцог 1кг нь хэдэн төгрөг гэх мэт</p> <p>Үйлдвэрлэсэн огноо, хадгалах хугацаа болон бусад нөхцөл тодорхой заагдсан, чанарын шаардлага хангасан, сав, баглаа боодол бүрэн бүтэн, тээвэрлэлтийн горим алдагдаагүй байх.</p> <p>Бүтээгдэхүүний гарал үүслийн бичгийг ирүүлнэ.</p>
2. Мах, дайвар бүтээгдэхүүн	1. Бүх төрлийн мал, амьтаны мах 2. малын гэдэс дотор 3. толгой шийр	кг	<p>Мах дайвар бүтээгдэхүүнд худалдан борлуулахаар зөвшөөрөгдсөн бүх төрлийн мал, амьтны мах, малын гэдэс дотор, толгой шийр орно. Хиам болон лаазалсан, дахин боловсруулсан бүтээгдэхүүн орохгүй.</p> <p>Гарал үүслийн гэрчилгээтэй, эрүүл ахуй, чанарын шаардлага хангасан тарган, өвчин эмгэггүй байх, тухайн малыг эрүүлжүүлэх зорилгоор вакцин болон ивоменк тарилга хийлгэсэн бол тарилга хийлгэсэн хугацаа нь уг малыг худалдахаас 21-ээс доошгүй хоногийн өмнө байх,</p> <p>Импортын бус байх,</p>
3. Сүү, сүүн бүтээгдэхүүн	1. Сүү 2. Аарц 3. Тараг	л. кг л	<p>Сүү нь өдөр тутмын шинэ байна. Бүх бүтээгдэхүүн гарал үүслийн гэрчилгээтэй байх, тараг исгэлэн байж болохгүй. Импортын бус байх.</p> <p>Нийлүүлэх хугацаанаас хамааран малын сүү, үйлдвэрийн сүүний үнийг салгаж өгөх</p>
4. Төмс, хүнсний ногоо	1. Төмс 2. Байцаа 3. Лууван 4. Манжин 5. Сонгино	кг	<p>Нутгийн хөрсөнд ургасан монгол сортын, гарал үүсэл тодорхой, шинэ, ургац үүсээгүй байна.</p> <p>Төмс, хүнсний ногоо гэдэгт дарсан ногоо буюу лаазалсан, даршилсан, дахин боловсруулсан махан бүтээгдэхүүн хамаарахгүй</p>

5.Будаа	1. Бүх төрлийн будаа	кг	Будаа гэдэгт бүх төрлийн будаа, хүүхдийн будаа, үр тариа, шар буурцагийн гаралтай бүтээгдэхүүн хамаарна. Үйлдвэрлэсэн огноо, хадгалах хугацаа болон бусад нөхцөл тодорхой заагдсан, чанарын шаардлага хангасан, сав, баглаа боодол бүрэн бүтэн, тээвэрлэлтийн горим алдагдаагүй байх Гарал үүслийн шинжилгээний бичгийг ирүүлнэ.
6. Жимс жимсгэнэ	1. алим 2. үзэм	кг	Жимс жимсгэнэд компот, жимсний чанамал, хатаасан жимс хамаарахгүй. Үйлдвэрлэсэн огноо, хадгалах хугацаа болон бусад нөхцөл тодорхой заагдсан, чанарын шаардлага хангасан байх
7. Ургамлын тос	1. Бүх нэр төрлийн, дотоодын ургамлын тос	л	Бүтээгдэхүүний нэр, хэмжээг тодорхой заасан байх Гарал үүслийн шинжилгээний бичгийг ирүүлнэ.
8. өндөг	1. өндөг	ш	Өдөр тутмын шинэ байна. Хадгалах хугацааны он сар, өдөр тодорхой байх.
9. Цөцгийн тос	1. Дотоодын, үйлдвэрийн цөцгий 2. Масло 3. цагаан тос, өрөм	кг	Үйлдвэрийн шардлага хангасан шинэ, нэр төрлийг тодорхой заасан байх Гарал үүслийн шинжилгээний бичгийг ирүүлнэ.
10. Элсэн чихэр	1. Элсэн чихэр	кг	Үйлдвэрлэсэн огноо, хадгалах хугацаа болон бусад нөхцөл тодорхой заагдсан, чанарын шаардлага хангасан, сав, баглаа боодол бүрэн бүтэн, тээвэрлэлтийн горим алдагдаагүй байх. Гарал үүслийн шинжилгээний бичгийг ирүүлнэ.

Тав. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(**Захиалагч байгууллагын нэр**)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [**санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр**] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [**тоо**] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3		4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ								

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

**6. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО
ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ**

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Долоо. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [моо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан моо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Найм. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|--|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. Бүтээгдэхүүний гарал үүслийн бичигтэй, чанар эрүүл ахуйн шаардлага хангасан байх. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | <p>2.1. Захиалагчийн байршилд буюу сумын төв дотор үйлчилгээг үзүүлнэ.</p> <p>Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:</p> <ol style="list-style-type: none">1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;2) барааг хүлээлгэн өгсөн баримт;3) барааны гарал үүслийн гэрчилгээ /мал эмнэлгийн шинжилгээ/4) баримтанд барааны нэр, төрөл, шошго, хаягийг тодорхой бичих <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5) | <p>5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.</p> <p>-шаардахгүй</p> |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | <p>7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:</p> <p>Гэрээний үнийн дүнг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн санхүүжилтийн хуваарийн дагуу тухайн сарын эцсээр [1] удаа төлнө.</p> <p>Санхүүжилтийг Аймгийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсээс олгоно.</p> |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹ | 9.1. Алданги оногдуулах хувь: тухйан үеийн үйлчилгээ үзүүлэх үнийн дүнгийн [0,1%] |

Ес. ГЭРЭЭНИЙ МАЯГТ²

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

² Гэрээбайгуулахүедүүнийгхасна.

³ Хоёрталхарилцантохиролцожгэрээнийнөхцөлдоруулсанзайлшгүйшаардлагатайнэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]